

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Х.Еркебулан
Утас: 99427667 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	УЛААНХУС СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА З.МУХТАР ТАНАА
<u>2024.02.23</u> № <u>244</u> танай _____ -ны № _____ -т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал</p>	
00402291	

байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>248,708,309.18</u>	<u>160,687,987.37</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	116,686,298.00	18,449,392.76
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	116,686,298.00	18,449,392.76
3121	Төгрөг	116,686,298.00	18,449,392.76
31211	Төрийн сангийн харилцах	116,686,298.00	18,449,392.76
33	АВЛАГА	-	25,848,984.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	25,848,984.00
35	БАРАА МАТЕРИАЛ	132,022,011.18	116,389,610.61
351	Түүхий эд материал	80,363,219.35	53,939,153.68
35130	Эм боох материал	80,363,219.35	53,939,153.68
354	Хангамжийн материал	51,658,791.83	62,450,456.93
35410	Бичиг хэргийн материал	171,800.00	198,900.00
35420	Аж ахуйн материал	43,177,529.75	48,545,329.75
35440	Түлш, шатах тослох материал	592,586.00	5,471,976.00
35460	Хүнсний материал	7,656,876.08	8,174,251.18
35470	Бусад хангамжийн материал	60,000.00	60,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,029,029,124.92</u>	<u>928,553,043.99</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,029,029,124.92	928,553,043.99
392	Биет хөрөнгө	1,013,829,124.92	913,353,043.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	816,446,956.40	758,414,981.31
39202	Хуримтлагдсан элэгдэл	(152,366,479.92)	(114,606,404.63)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	128,532,132.00	128,532,132.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(64,833,248.73)	(81,583,247.09)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	301,554,659.42	307,950,959.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(91,126,897.62)	(148,343,386.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,199,110.70	96,782,780.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,534,885.06)	(37,405,882.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,200,000.00	5,200,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,242,222.27)	(1,588,888.95)
393	Биет бус хөрөнгө	15,200,000.00	15,200,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,200,000.00	15,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,277,737,434.10</u>	<u>1,089,241,031.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>14,012,842.00</u>	<u>20,258,784.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,012,842.00	20,258,784.00
413	Өглөг	14,012,842.00	20,258,784.00

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4136	Бусад өглөг	14,012,842.00	20,258,784.00
41361	Байгууллагад төлөх өглөг	14,012,842.00	20,258,784.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,263,724,592.10</u>	<u>1,068,982,247.36</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,263,724,592.10	1,068,982,247.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	376,160,585.01	376,160,585.01
51101	Өмч: - төрийн	376,160,585.01	376,160,585.01
512	Хуримтлагдсан үр дүн	563,579,452.30	414,812,096.22
51210	Өмнөх үеийн үр дүн	563,579,452.30	609,554,440.96
51220	Тайлант үеийн үр дүн	-	(194,742,344.74)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	323,984,554.79	278,009,566.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,277,737,434.10</u>	<u>1,089,241,031.36</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,452,988,330.70	1,267,659,280.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	163,020,960.70	40,403,176.00
120	Нийтлэг татварын бус орлого	163,020,960.70	40,403,176.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	20,060,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	20,060,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	90,803,712.26	5,676,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	72,217,248.44	14,666,876.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,289,967,370.00	1,227,256,104.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,621,100.00	34,647,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,621,100.00	34,647,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,257,346,270.00	1,192,608,404.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,257,346,270.00	1,192,608,404.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,284,653,617.60	1,461,484,958.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,284,653,617.60	1,461,484,958.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,284,653,617.60	1,461,484,958.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	792,921,543.00	928,098,395.66
210101	Үндсэн цалин	484,724,543.00	409,615,498.66
210102	Нэмэгдэл	189,600,100.00	381,760,643.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,342,000.00	18,529,000.00
210104	Урамшуулал	69,194,100.00	118,193,254.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,060,800.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,136,928.00	116,169,666.28
210201	Тэтгэврийн даатгал	59,293,028.00	55,298,166.28
210202	Тэтгэмжийн даатгал	7,324,400.00	15,217,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,716,100.00	12,174,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,471,800.00	3,043,700.00

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	24,331,600.00	30,435,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,893,442.00	39,966,112.00
210301	Гэрэл, цахилгаан	3,585,647.00	5,066,074.00
210302	Түлш, халаалт	27,307,795.00	34,900,038.00
2104	Хангамж, бараа материалын зардал	85,383,505.50	90,399,895.00
210401	Бичиг хэрэг	4,766,050.00	4,415,100.00
210402	Тээвэр, шатахуун	67,055,653.50	66,782,795.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,973,100.00	3,622,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	630,000.00	3,644,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,958,702.00	11,935,500.00
2105	Нормативт зардал	131,667,662.21	142,514,755.57
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	105,127,837.25	133,697,130.67
210502	Хоол, хүнс	18,242,824.96	8,817,624.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,297,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,159,659.00	16,240,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,627,200.00	12,840,300.00
210604	Урсгал засвар	7,532,459.00	3,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,210,000.00	2,503,000.00
210702	Дотоод албан томилолт	1,210,000.00	2,503,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,127,380.00	433,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	164,000.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,900.00	132,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	101,480.00	101,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,153,497.89	125,159,384.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,888,100.00	5,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	121,265,397.89	119,659,384.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	168,334,713.10	(193,825,678.13)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,948,334.00	916,666.61
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,948,334.00	916,666.61
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(15,948,334.00)	(916,666.61)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	152,386,379.10	(194,742,344.74)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,336,357,870.00	1,221,467,120.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	20,060,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	20,060,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	20,060,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		20,060,000.00

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,336,357,870.00	1,201,407,120.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,621,100.00	34,647,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,621,100.00	34,647,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,303,736,770.00	1,166,759,420.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,303,736,770.00	1,166,759,420.70
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,156,834,814.00	1,305,280,355.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,156,834,814.00	1,305,280,355.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,156,834,814.00	1,305,280,355.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	779,379,260.00	918,750,581.94
210101	Үндсэн цалин	471,182,260.00	543,075,381.94
210102	Нэмэгдэл	189,600,100.00	263,563,122.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,342,000.00	12,061,000.00
210104	Урамшуулал	69,194,100.00	100,051,078.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,060,800.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,679,211.00	125,517,480.00
210201	Тэтгэврийн даатгал	83,905,911.00	82,404,780.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,324,400.00	10,778,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,716,100.00	8,622,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,465,200.00	2,155,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,267,600.00	21,556,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,096,200.00	34,647,700.00
210301	Гэрэл, цахилгаан	3,585,647.00	5,303,600.00
210302	Түлш, халаалт	26,510,553.00	29,344,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	85,628,684.00	88,257,155.00
210401	Бичиг хэрэг	4,712,950.00	4,442,200.00
210402	Тээвэр, шатахуун	71,648,734.00	70,734,655.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,973,100.00	3,612,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		5,908,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,416,000.00	3,559,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,877,900.00	
2105	Нормативт зардал	116,824,377.00	107,235,389.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,144,527.00	97,900,889.00
210502	Хоол, хүнс	13,166,850.00	9,334,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,513,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,429,102.00	21,162,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,760,402.00	8,822,200.00
210604	Урсгал засвар	7,668,700.00	12,340,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,210,000.00	2,503,000.00
210702	Дотоод албан томилолт	1,210,000.00	2,503,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,127,380.00	433,450.00

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	164,000.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,900.00	132,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	101,480.00	101,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,460,600.00	6,773,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,460,600.00	6,773,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>179,523,056.00</u>	<u>(83,813,235.24)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	63,974,798.00	14,423,670.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,974,798.00	14,423,670.00
2200	Дотоод эх үүсвэрээр	63,974,798.00	14,423,670.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	63,974,798.00	14,423,670.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(63,974,798.00)</u>	<u>(14,423,670.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	115,548,258.00	(98,236,905.24)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,138,040.00	116,686,298.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	116,686,298.00	18,449,392.76

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	376,160,585.01	323,984,554.79	-57,533,022.66	642,612,117.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			46,390,500.00	46,390,500.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	376,160,585.01	323,984,554.79	-11,142,522.66	689,002,617.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			574,721,974.96	574,721,974.96
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	376,160,585.01	323,984,554.79	563,579,452.30	1,263,724,592.10
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	376,160,585.01	323,984,554.79	563,579,452.30	1,263,724,592.10

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			45,974,988.66	45,974,988.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	376,160,585.01	323,984,554.79	609,554,440.96	1,309,699,580.76
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-45,974,988.66		-45,974,988.66
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00			0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-194,742,344.74	-194,742,344.74
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	376,160,585.01	278,009,566.13	414,812,096.22	1,068,982,247.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		116,686,298.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,418,571,400.00	1,319,704,025.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,418,571,400.00	1,319,704,025.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,418,571,400.00	1,319,704,025.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	946,693,600.00	918,750,581.94
210101	Үндсэн цалин	559,259,300.00	543,075,381.94
210102	Нэмэгдэл	264,826,800.00	263,563,122.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,858,000.00	12,061,000.00
210104	Урамшуулал	110,749,500.00	100,051,078.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,121,700.00	125,517,480.00
210201	Тэтгэврийн даатгал	92,562,700.00	82,404,780.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,889,800.00	10,778,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,711,800.00	8,622,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,178,000.00	2,155,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,779,400.00	21,556,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,647,700.00	34,647,700.00
210301	Гэрэл, цахилгаан	5,303,600.00	5,303,600.00
210302	Түлш, халаалт	29,344,100.00	29,344,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	92,480,800.00	88,257,155.00
210401	Бичиг хэрэг	4,844,700.00	4,442,200.00
210402	Тээвэр, шатахуун	70,750,200.00	70,734,655.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,816,000.00	3,612,000.00

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,192,000.00	5,908,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,877,900.00	3,559,600.00
2105	Нормативт зардал	137,060,700.00	107,235,389.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	115,716,700.00	97,900,889.00
210502	Хоол, хүнс	13,459,100.00	9,334,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,884,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,136,800.00	35,586,170.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,840,200.00	12,840,200.00
210604	Урсгал засвар	23,296,600.00	22,745,970.00
2107	Томилолт, зочны зардал	2,603,800.00	2,503,000.00
210702	Дотоод албан томилолт	2,603,800.00	2,503,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	527,400.00	433,450.00
210803	Даатгалын үйлчилгээ	164,000.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,900.00	132,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	101,500.00	101,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,298,900.00	6,773,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,298,900.00	6,773,100.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,301,885,200.00	1,221,467,120.70
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,647,700.00	34,647,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	34,647,700.00	34,647,700.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,247,177,500.00	1,166,759,420.70
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,247,177,500.00	1,166,759,420.70
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,060,000.00	20,060,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,060,000.00	20,060,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		116,686,298.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		18,449,392.76
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО		
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	49.00	54.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	38.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00
620004	Гэрээт ажилтан		5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	49.00	54.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	41.00	39.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	10.00
650010	Гэрээт ажилтан		5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай, үзүүлэх үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэхэд оршино гэсэн эрхэм зорилготой байгууллага юм.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, оношилгоо шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх,
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тогтмол хүргэх
- Эхийн эндэгдэл гаргахгүй байх, эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах
- Хүүхдийн эндэгдлийг буруулах
- Халдварт болон халдварт бус өвчнийг буруулах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузел суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд дотоод аудитын шалгалтад хамрагдаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 13 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 194.7 сая төгрөгөөр буюу 15.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	116,686.3	18,449.4	(98,236.9)
Авлага	-	25,849.0	25,849.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	132,022.0	116,389.6	(15,632.4)
Үндсэн хөрөнгө	1,029,029.1	928,553.0	(100,476.1)
Нийт хөрөнгө	1,277,737.4	1,089,241.0	(188,496.4)
Өр төлбөр	14,012.8	20,258.8	6,246.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,263,724.6	1,068,982.2	(194,742.4)

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 18.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 98.2 сая төгрөгөөр буурсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 25.8 сая төгрөгийн санхүүжилтийн авлагатай гарсан байна.

Бараа материалын данс 15.6 сая төгрөгөөр буурсан нь 216.1 сая төгрөгийн материал худалдан авч, 14.7 сая төгрөгийн материал үнэгүй хүлээн авч, 246.4 сая төгрөгийн материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 100.5 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 14.4 сая төгрөгийн хөрөнгө худалдаж авч, 5.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө Эрүүл мэндийн яамнаас шилжүүлэн

авч, 67.2 сая төгрөгөөр аймгийн ИТХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 182 тоот тогтоолоор дуудлага худалдаагаар эмнэлгийн хуучин байр, эмнэлгийн орыг худалдсантай холбоотой байна.

Өр төлбөрийн данс 6.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь халаалтын зардлын өглөг байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 194.7 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр зарлагын нийт дүнг 1,518.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшил 946.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 136.1 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 34.5 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 92.5 сая төгрөгөөр, норматив зардлыг 137.0 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 36.1 сая төгрөгөөр, томилот, зочны зардал 2.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 0.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 32.3 сая төгрөгөөр багасгаж, нийтдээ 99.4 сая төгрөгөөр хасаж, 1,418.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,383.9 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 34.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,221.5 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,221.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 34.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээс 98.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,319.7 сая төгрөг буюу 93.0 хувьтай байна. Жилийн эцэст Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,186.8 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 34.6 сая төгрөг, мөнгөний эхний үлдэгдлээс 98.3 сая төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнд ноогдох норматив	930,413.1	867,876.6	62,536.5	93.3%
2	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	316,764.4	280,433.5	36,330.9	88.5%
3	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	136,746.2	136,746.2	0	100%

4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	34,647.7	34,647.7	0	100%
	Дүн	1,418,571.4	1,319,704.0	98,867.4	93.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,284.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,461.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 21.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор эм, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, нормын хувцас зөөлөн эдлэл, бараа үйлчилгээний бусад зардлыг нийтдээ 98.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 788.1 сая төгрөгийн 15 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5.0 сая төгрөгийн 1 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 25.3 сая төгрөгийн 7 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр сорил хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 0.6 сая төгрөгийн акт, 16.0 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	0.6	1	0.6	100
Албан шаардлага	1	16.0	1	16.0	100
Зөвлөмж					
Нийт дүн	2	16.6	2	16.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								